



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 5/31

Хэрлэн сум

Л.Мэндбаярыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1, 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 93 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албаны удирдах албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн Лхамсүрэнгийн Мэндбаярыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Зоригтбаатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

Гишүүд: Б.Цэцэгсайхан Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

Ц.Алтан-Өлзий Аймгийн Эрүүл мэндийн газрын Нягтлан бодогч

Э.Майцэцэг Аймгийн Эрүүл мэндийн газрын Архив, албан хэрэг хариуцсан мэргэжилтэн

Т.Байгальсүрэн Аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

3. Л.Мэндбаярын үндсэн цалинг ТЗ-4 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалин 1,757,000 (нэг сая долоон зуун тавин долоон мянга) төгрөгөөр тооцож, холбогдох бусад нэмэгдлийг хууль, журамд заасны дагуу олгохыг аймгийн Эрүүл мэндийн газрын Нягтлан бодогч (Ц.Алтан-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

2.

4.Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Л.Мэндбаяарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

